

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/35/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Орхон аймаг 2024 он	Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
	Аудитор: Г.Даваасүрэн Утас: 70357855 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.25 № 68
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.ГАНЗОРИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаал, 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/15 дугаар тушаалаар ажлын албаны төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл, албан тушаалын цалингийн хэмжээг батлахдаа Төрийн үйлчилгээний 8 алба хаагчийн цалинг Засгийн газраас тогтоосон доод хэмжээнээс 40 хувиар нэмэгдүүлэн баталж, сар бүр олгосон байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь "Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015", "Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015" олон улсын стандартуудыг хэрэгжүүлж, 3,828.0 мянган төгрөгөөр магадлан аудитад хамрагдаж 1 жилийн хугацаатай гэрчилгээг сунгуулсан.

Мэдээллийн технологийн аюулгүй байдалд олон улсын чанарын менежментийн ISO 27001:2021 нэвтрүүлж, мэргэжлийн зөвлөмж дэмжлэг үзүүлэхэд

19,800.0 мянган төгрөг зарцуулж, мэдээллийн технологийн аюулгүй байдалд олон улсын чанарын менежментийн тогтолцооны баталгаажуулалт болон магадлах аудитыг 14,450.0 мянган төгрөгөөр хийлгэж гэрчилгээг авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тайлант онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардалд 411,500.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 376,974.2 мянган төгрөг зарцуулсан, Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрт 210,000.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 196,657.2 мянган төгрөг, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай намд олгох санхүүжилтэд 700,000.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 700,000.0 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгааны зардалд 142,000.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 123,715.0 мянган төгрөг, хэлмэгсдийн ар гэрт зориулж 42,234.5 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 37,961.1 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох бусад тэтгэмжийн зардлыг 92,550.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 92,513.9 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>64,293,065.40</u>	<u>41,761,351.68</u>
33	АВЛАГА	29,400,000.00	70,998.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	70,998.00
335	Бусад авлага	29,400,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	29,400,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	34,893,065.40	41,690,353.68
351	Түүхий эд материал	25,933,383.40	30,606,691.68
35110	Тусгай зориулалттай материал	25,933,383.40	30,606,691.68
354	Хангамжийн материал	8,959,682.00	11,083,662.00
35410	Бичиг хэргийн материал	1,275,260.00	3,399,240.00
35450	Барилгын засварын материал	7,684,422.00	7,684,422.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>291,839,292.15</u>	<u>279,617,185.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	291,839,292.15	279,617,185.48
392	Биет хөрөнгө	289,879,292.15	277,657,185.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	15,190,135.00	15,190,135.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,550,414.40)	(1,972,362.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	79,815,000.00	79,815,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,000,000.08)	(24,963,000.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	257,608,960.00	289,174,769.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(99,026,596.65)	(140,018,415.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,866,910.00	101,996,010.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,967,201.72)	(43,017,450.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,900,000.00	24,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,957,500.00)	(23,447,500.00)
393	Биет бус хөрөнгө	1,960,000.00	1,960,000.00
39301	Програм хангамж	462,000.00	462,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(462,000.00)	(462,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,960,000.00	1,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>356,132,357.55</u>	<u>321,378,537.16</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>70,998.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	70,998.00
413	Өглөг	-	70,998.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	70,998.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>219,910,883.89</u>	<u>185,086,065.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	219,910,883.89	185,086,065.50
512	Хуримтлагдсан үр дүн	218,156,222.24	183,331,403.85
51210	Өмнөх үеийн үр дүн	218,156,222.24	218,156,222.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	(34,824,818.39)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,754,661.65	1,754,661.65

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>219,910,883.89</u>	<u>185,157,063.50</u>
---	--	-----------------------	-----------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,384,768,715.00	3,281,558,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,384,768,715.00	3,281,558,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	407,208,915.00	354,859,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,008,915.00	60,459,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	327,200,000.00	294,399,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,977,559,800.00	2,926,699,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,977,559,800.00	2,926,699,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,497,163,394.42	3,316,383,018.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,497,163,394.42	3,316,383,018.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,650,785,029.95	1,863,274,463.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,026,743.00	574,921,647.99
210101	Үндсэн цалин	191,458,556.00	318,887,514.20
210102	Нэмэгдэл	50,044,873.00	165,023,314.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,910,252.00	60,255,000.00
210104	Урамшуулал	8,613,062.00	30,755,819.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,336,319.13	70,861,141.64
210201	Тэтгэврийн даатгал	24,041,851.17	49,349,192.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,827,994.32	5,805,787.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,129,703.76	4,591,829.79
210204	Ажилгүйдлийн даатгал	480,638.86	1,010,393.57
210205	Эрүүл мэндийн даатгал	4,856,131.02	10,103,938.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	864,000.00	864,000.00
210304	Байрны түрээс	864,000.00	864,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,124,196.00	41,683,472.04
210401	Бичиг хэрэг	6,877,356.00	6,971,970.00
210402	Тээвэр, шатахуун	25,808,621.00	24,791,089.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,482,709.00	4,947,413.04
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,955,510.00	4,973,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,996,799.00	39,591,248.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,999.00	1,283,198.00
210604	Урсгал засвар	19,979,800.00	38,308,050.00
2107	Томилолт, зочны зардал	8,633,980.00	83,015,291.00
210701	Гадаад албан томилолт	-	41,048,571.00
210702	Дотоод албан томилолт	8,633,980.00	41,966,720.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	276,113,786.56	477,734,751.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	271,104,035.56	459,659,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,362,000.00	4,390,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	253,751.00	253,751.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	13,340,000.00
210807	Газрын төлбөр	-	14,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,002,689,206.26	574,602,911.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	911,086,755.44	483,936,606.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,184,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,602,450.82	85,482,305.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	846,378,364.47	1,453,108,554.77
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	350,000,000.00	729,400,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	350,000,000.00	729,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	450,747,835.60	518,426,770.44
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,388,135.00	3,007,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	331,404,316.00	411,641,697.44
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	34,920,323.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,955,384.60	68,857,450.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	45,630,528.87	205,281,784.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,630,528.87	205,281,784.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(112,394,679.42)	(34,824,818.39)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(112,394,679.42)	(34,824,818.39)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,384,768,715.00	3,281,558,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,384,768,715.00	3,281,558,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	407,208,915.00	354,859,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,008,915.00	60,459,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	327,200,000.00	294,399,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,977,559,800.00	2,926,699,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,977,559,800.00	2,926,699,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,366,998,715.00	3,208,298,001.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,366,998,715.00	3,208,298,001.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,557,787,215.13	1,780,263,479.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,023,381.00	573,673,799.99
210101	Үндсэн цалин	191,455,194.00	316,669,897.20

210102	Нэмэгдэл	50,044,873.00	165,023,314.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,910,252.00	61,224,769.00
210104	Урамшуулал	8,613,062.00	30,755,819.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,336,319.13	70,861,141.64
210201	Тэтгэврийн даатгал	24,041,851.17	48,886,852.27
210202	Тэтгэмжийн даатгал	2,827,994.32	5,751,394.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,129,703.76	4,591,829.79
210204	Ажилгүйдлийн даатгал	480,638.86	1,010,393.57
210205	Эрүүл мэндийн даатгал	4,856,131.02	10,620,671.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	864,000.00	864,000.00
210304	Байрны түрээс	864,000.00	864,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,510,790.00	43,361,592.04
210401	Бичиг хэрэг	3,706,300.00	8,115,450.00
210402	Тээвэр, шатахуун	25,608,621.00	24,791,089.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,580,359.00	5,337,413.04
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,615,510.00	5,117,640.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,209,800.00	43,963,348.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,230,000.00	5,655,298.00
210604	Урсгал засвар	19,979,800.00	38,308,050.00
2107	Томилолт, зочны зардал	8,633,980.00	83,015,291.00
210701	Гадаад албан томилолт	-	41,048,571.00
210702	Дотоод албан томилолт	8,633,980.00	41,966,720.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	274,855,401.00	488,544,751.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,166,900.00	470,469,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,362,000.00	4,390,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	253,751.00	253,751.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,028,750.00	13,340,000.00
210807	Газрын төлбөр	-	14,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	911,353,544.00	475,979,556.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	911,353,544.00	470,795,556.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,184,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	809,211,499.87	1,428,034,521.33
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	350,000,000.00	700,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	350,000,000.00	700,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	405,783,451.00	521,646,424.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,388,135.00	3,112,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	331,404,316.00	418,919,001.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	34,920,323.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,991,000.00	64,694,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	53,428,048.87	206,388,097.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	45,630,528.87	205,281,784.33
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,797,520.00	1,106,313.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,770,000.00	73,260,199.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,770,000.00	73,260,199.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,770,000.00	73,260,199.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,770,000.00	73,260,199.00
223001	Бусад хөрөнгө	17,770,000.00	73,260,199.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(17,770,000.00)	(73,260,199.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,221,473.66	1,754,661.65	218,156,222.24	356,132,357.55
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	136,221,473.66	1,754,661.65	218,156,222.24	356,132,357.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	136,221,473.66	1,754,661.65	218,156,222.24	356,132,357.55
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(34,824,818.39)	(34,824,818.39)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	136,221,473.66	1,754,661.65	183,331,403.85	321,307,539.16

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43,963.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 43,963.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эд хогшил, урсгал засварын зардал хасах дүнтэй илэрхийлэгдсэнийг 43,963.3 мянган төгрөг болгон залруулсан.

Аудитаар нийт 54,596.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 4,027.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 36,057.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 14,512.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илүү цагийг олгох ёстой хэмжээнээс хэтрүүлэн 2,015.9 мянга, шөнийн нэмэгдэл цалинг хууль журамд зааснаас илүү хэмжээгээр тооцсонд 1,306.1 мянга, хоол унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан олгосон 705.0 мянган төгрөг, нийт 4,027.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Гадаад томилолтын зардлаас 36,057.7 мянган төгрөгийг үр ашиг, үр дүн тодорхойгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 210402 шатахууны зардлаас 23,811.1 мянга, албан томилолтын зардлаас 11,588.4 мянга нийт 35,399.5 мянган төгрөгийн тээвэр шатахуун зарцуулснаас 14,441.2 мянган төгрөгийн шатахууныг шууд зардлаар тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.2-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө", 14.3-д "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх", 14.3.2-д "журналд бичих", 14.3.3-д "дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тээвэр шатахууны зардлыг бараа материалын дансаар дамжуулан хяналттай зарцуулж байх.

2. Авлага өр төлбөртэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Тайлант оны эхэнд 29,400.0 мянган төгрөгийн авлагатай байсан бол бүрэн барагдаж, оны эцэст 70.9 мянган төгрөгийн авлага, өр төлбөр бүртгэгдсэн байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

3. Тушаал шийдвэртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 66 дугаар тогтоолоор бүтэц орон тоо батлахдаа Засгийн газрын 275, 276 дугаар тогтоолыг үндэслэл болгон баталсан бөгөөд уг тогтоолууд нь 2022 онд хүчингүй болсон байна.

Өгсөн зөвлөмж: Шинэчлэгдэн гарсан хууль, журамтай уялдуулан бүтэц орон тоог шинэчлэн батлах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эд хогшил, урсгал засварын зардал хасах дүнтэй илэрхийлэгдсэнийг 43,963.3 мянган төгрөгөөр залруулсан.	1	43,963.3					1	43,963.3				
Дүн	1	43,963.3					1	43,963.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Илүү цагийг олгох ёстой хэмжээнээс хэтрүүлэн 2,015.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.	1	2,015.9	1	2,015.9								
Шөнийн нэмэгдэл цалинг хууль журамд зааснаас илүү хэмжээгээр тооцсонд 1,306.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.	1	1,306.1	1	1,306.1								
хоол унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан олгосон 705.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоов.	1	705.0	1	705.0								
Гадаад томилолтын зардлаас 36,057.7 мянган төгрөгийг үр ашиг, үр дүн тодорхойгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.	1	36,057.7			1	36,057.7						
14,441.2 мянган төгрөгийн шатахууныг шууд зардлаар тайлагнасан тул бараа материалаар дамжуулан зарцуулах.	1	14,441.2					1	14,441.2				

Оны эцэст 70.9 мянган төгрөгийн авлага, өр төлбөр бүртгэгдсэн тул төсвийн хөрөнгийг өглөг авлагагүй зохистой удирдах.	1	70.9					1	70.9				
Аймгийн ИТХ-ын хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 66 дугаар тогтоолоор бүтэц орон тоо батлахдаа Засгийн газрын 275, 276 дугаар тогтоолыг үндэслэл болгон баталсан бөгөөд уг тогтоолууд нь 2022 онд хүчингүй болсон байна.	1	0					1	0				
Дүн	7	54,596.8	3	4,027.0	1	36,057.7	3	14,521.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								